

БАТЛАВ.
“ГҮНИЙ-УС” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЭНХЧИМЭГ

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Байгууллагын нэр	Хэсгийн нэр	
“Гүний-ус” ХХК	Ус хангамжийн хэсэг	
Ажлын байрны нэр	Хавсран гүйцэтгэх ажил	Дугаар
Жолооч	Засварчин	¹
Шууд харьяалагдах ажлын байр	Шууд харьяалах албан тушаал	
Гүйцэтгэх захирал	Үйлдвэрлэл үйлчилгээний хэсэг, түүний ажилчид	
Ажлын байрны зорилго	Компанийн зорилт, эрхэм зорилгыг эрхэмлэн ажиллах	

1. Ажлын байрны үндсэн чиг үүрэг:

1. Байгууллагаас зохиосон мэргэжлийн болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцох, шаарлагатай тохиолдолд үйлдвэрийн аль ч объектод ажил амралтын ямарч нөхцөлд бэлэн байхын зэрэгцээ, ээлжийн амралтаа зохицуулан илүү цагаар ажиллах
2. ХХАА-ны үе шатны зааварчилгууд, нийтийн аж ахуйн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, стандартыг ажилдаа мөрдлөг болгон осол, аваар зөрчилгүй ажиллах
3. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгыг мөрдөн ажиллах
4. Ажил үйлдвэрлэлийн технологийн горимыг хатуу баримталж, ажлын бүтээмжийг өндөр байлгах, ажлын цагийг баримтлах, ажлын байрыг дур мэдэн орхих, чөлөө зөвшөөрөлгүй явах, ажил таслах, чөлөөний хугацаа хэтрүүлэх, ажилтан болон бусдад сөрөг нөлөөлөл учруулахгүйгээр ажиллаж, хөдөлмөрлөх
5. Үйлдвэрлэлийн осол, гэмтэлд өртөхгүй байхын тулд мөрдөж ажиллах “БҮҮ МАРТ-10” зарчмыг ажилдаа хэвшүүлж ажиллах
6. Өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг байнга төлөвлөлттэйгөөр хөгжүүлж, сорилын болон улирал тутамд зохион байгуулагдах мэргэжлийн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шалгалтанд манлайлж ажиллах
7. Хууль журам, дүрэм, стандарт, заавар, зааварчилгыг уншин судлан, өөрийн болгож улирал тутам мэргэжлийн сургалт, шалгалтанд хамрагдаж ажиллах
8. Байнгын болон орон тооны бус комисс, ажлын хэсэгт ажиллах ба ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган үр дүнг удирдлагад тайлагнаж, мэдээ тайланг гаргаж ажиллах
9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах ба Цэвэр бохир усны техникийн бүлэг, Уст цэгийн хамгаалах бүлгийн бие бүрэлдэхүүнд бэлэн байхын зэрэгцээ хээрийн сургууль, дадлага сургууль, өндөржүүлсэн буюу онц байдал зарласан үед шуурхай арга хэмжээ авч, удирдлага, зохион байгуулалтаар хангагдан ажиллах
10. Учирч болзошгүй эрсдэлээс сэрэмжлэн, аюулыг мэдээлж, илэрсэн зөрчил, гэмтлийг тухай бүрт нь мэргэжлийн ажилчнаар засварлуулан ажиллах
11. Ажлын байран дахь цахилгааны болон галын аюулгүй байдлыг ханган ажиллах
12. Ажил үүрэг гүйцэтгэж байгаа тухайгаа ээлжийн диспетчерт заавал мэдэгдэж, бүртгүүлж ажиллах

2. Ажлын байрны чиг үүрэг:

1. Эзэмшиж байгаа техниктээ засвар үйлчилгээг тогтмол хийж, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг ханган сэлбэг шатахууны тооцоог хийж ажиллах
2. Автомашины хадгалалт хамгаалалт, найдвартай ажиллагааг хангах, эд анги нэг бүрийн нормын хугацааг дуустал ажиллах үйлчилгээний дэвшитэт арга туршлагыг ажилдаа нэвтрүүлэх талаар санаачилга гаргаж, эзний ёсоор хандана.
3. Хариуцсан авто машиныг ажлын бус цагаар гараашид буюу зөвшөөрөгдсөн газарт тавьж, аж ахуйн хашааны сахиул буюу диспетчерт мэдэгдэн бүртгэл хөтлүүлнэ.
4. Компанийн салбар нэгж, шугам сүлжээнд гарсан аваар ослын үед дуудагдан ажиллах тохиолдолд авто машины ажиллагаа хэвийн байх ажлыг хариуцна.
5. Гагнуурын ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг ханган ажиллах.
6. Эзэмшсэн машин, техник, механизмаа байнгын бэлэн байдалд байлгах.
7. Төлбөрт үйлчилгээгээр компанид орлого оруулах талаар санаачилгатай ажиллах
8. Механизм, машин техник, тоног төхөөрөмжид шаардлагатай сэлбэг материалыг салбар хариуцсан удирдах ажилтанд мэдэгдэж, бизнес төлөвлөгөөнд тусгуулах ба зарцуулалтыг төлөвлөгөөтэй уялдуулан зарцуулах
9. Өөрийн эзэмшилд байгаа машин механизмыг гараш болон зөвшөөрөгдсөн газраас бусад газарт тавихыг хориглоно.
10. Шугам сүлжээний угсралтын ажлын стандартын шаардлагыг ханган ажиллана
11. Хөдөөгийн ба хот доторхи замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний дүрмийг баримтлах ба хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах
12. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ агаарын шугам, цахилгаан, холбооны кабель, газар доорхи шугам сүлжээ байгаа эсэхийг тодруулж, онцгой анхаарч ажиллах
13. Ирсэн дуудлага үйлчилгээг шуурхай барагдуулж ажиллана

3. Ажлын байранд тавигдах шаардлагууд:

	Мэргэжил	жолооч
	Боловсрол	Бүрэн бус дунд
Ерөнхий шаардлага	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Харилцааны болон хамтран ажиллах чадвартай • Техник машин механизмд засвар үйлчилгээ хийх чадамжтай • Ачаалал даах чадвартай, техник сэтгэлгээтэй • Замын хөдөлгөөнд оролцох бүрэн эрхтэй, суурин болон хөдөөгийн замд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай • Гаж зуршилгүй, сэтгэл санаа тогтвортой
		<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдаж ажиллах • Эд хөрөнгө эзэмших гэрээг аж ахуйн няравтай байгуулж ажиллах
Тусгай шаардлага		

Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	<ul style="list-style-type: none">• Албан тушаалын цалин, нэмэгдэл, нөхөн төлбөр, тусламж, тэтгэмж, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллах• Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа Засгийн Газраас тогтоосон Хөдөлмөрийн хөлсний өөрчлөлтийг мөрдөж ажиллах• Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг хариуцах
	Ажлын байр	<ul style="list-style-type: none">• Гэнэтийн ослын даатгалд даатгуулах• Шаардлагатай тохиолдолд унаанд шатахуун, утсанд нь ярианы эрх буюу нэгж олгоно• Мэргэжлийн болон ур чадварын сургалтанд хамруулах• Багаж, сэлбэг хэрэгслээр хангана.
Ажлын байрны нөхцөл: Хэвийн		
Ажлын байр: Жолооч- засварчин		

4. Ажлын байрны тодорхойлолт:

Боловсруулсан:	Хянасан:
Хүний нөөцийн менежер:	Ерөнхий инженер: С.Отгончулуун/